

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 03-р сарын 11-ний өдөр

№ 05/26

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх заалт, 64 дүгээр зүйлийн 64.2 дахь заалт, 65 дугаар зүйлийн 65.1, 65.4 дэх заалт, 71 дүгээр 71.1, 71.3, 71.4 дэх заалт, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалтууд болон Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 03-р сарын 11-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “БидиСЕК ҮЦК” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 4 сарын 29-ний өдөр 10 цагт <https://agm.mn/> холбоосоор цахим хэлбэрээр хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 - а) Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах,
 - б) Ногдол ашиг хуваарилах тухай ТҮЗ-ийн тогтоолыг танилцуулах,
 - в) Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах,
 - д) Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох,
 - е) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсөв батлах,
 - ф) Аудитын байгууллагыг сонгох.
3. Хурлыг зарлах тухай мэдэгдлийг 2026 оны 03 сарын 13-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлсүгэй.
4. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин,

орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр болон компанийн цахим хуудсаар дамжуулан 2026 оны 03 сарын 16-ны өдөр нийтэд мэдээлж, уг зарыг 2026 оны 03 сарын 31-ний өдөр дахин нийтэд мэдээлсүгэй.

5. Ногдол ашиг авах болон хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 04 сарын 02 өдрөөр тогтоосугай.
6. Хурлын зарын загвар, хэлэлцэх асуудлыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
7. Хурлын дэгийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
8. Хурлын танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг гуравдугаар хавсралтаар баталсугай
9. Хурлын саналын хуудасны загварыг дөрөвдүгээр хавсралтаар баталсугай.
10. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, танилцуулга саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2026 оны 03 сарын 20-ний өдөрт багтаан үнэт цаасны брокер дилерийн компанид хүргүүлсүгэй. Хурлын материалтай ажлын өдрийн 09:00-17:00 цагийн хооронд танилцах боломж бүрдүүлэхийг Гүйцэтгэх захирал болон Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
11. Хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдэд саналаа урьдчилан өгөх боломжоор хангаж Компанийн өөрийн байранд урьдчилсан саналын хуудсыг хүлээн авах ба саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа 2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 15:00 цаг байна.
12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын даргаар Т.Шүүдэрцэцэг, гишүүнээр М.Оюунсүвд нарыг тус тус томилсугай.
13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга Д.Даянбилгүүн, тооллогын комиссын даргаар “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Хөрөнгө оруулалтын албаны захирал С.Дөлгөөн, гишүүнээр “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн мэргэжилтэн Б.Хулан нарыг тус тус томилсугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:**



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 03-р сарын 11-ний өдөр

№ 06/26

Улаанбаатар хот

Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг дүгнэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт,
Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 03-р сарын 11-ний өдрийн
ээлжит хурлын шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланг хангалттай гэж дүгнэсүгэй.
2. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт, тайланг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хэлэлцүүлэхийг ТУЗ-ийн дарга (Д.Даянбилгүүн)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 03-р сарын 11-ний өдөр

№ 07/26

Улаанбаатар хот

Компанийн бизнес төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.2.12 дэх заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 03-р сарын 11-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн бизнес төлөвлөгөөг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Компанийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Лхагвадорж)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 03-р сарын 11-ны өдөр

№ 08/26

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн Бичгийн Дарга томилох тухай

Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дахь заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 03 сарын 11-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “БидиСЕК” ҮЦК ХК – ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн Бичгийн Даргаар Түмэнбаяр овогтой Шүүдэрцэцэг-ийг томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 03-р сарын 11-ний өдөр

№ 09/26

Улаанбаатар хот

Охин компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, “БиДиСЕК ҮЦК” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн холбогдох заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 03-р сарын 11-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Икс гурав Зэт Эй” ХХК-ийг ердийн гурван гишүүний бүрэлдэхүүнтэй Төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар тогтоосугай.
2. “Икс гурав Зэт Эй ББСБ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр дараах гишүүдийг томилсугай.
 - а. Монгол Улсын иргэн Данзан овогтой Даянбилгүүн
 - б. Монгол Улсын иргэн Бүрэнмэнд овогтой Лхагвадорж
 - с. Монгол улсын иргэн Бат-Оргил овогтой Онон
3. Компанийн шинэчилсэн дүрмийг энэхүү тогтоолийн нэгдүгээр хавсралтаар баталсугай.
4. “Икс гурав Зэт Эй” ХХК-ийн үйл ажиллагаанд мөрдөгдөх Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын журам, Зээлийн үйл ажиллагааны журам болон холбогдох бусад журмуудыг батлах, зээлийн хүү тогтоох болон Компанийн тухай хуульд заасан холбогдох бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэн ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд зөвшөөрсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 03-р сарын 11-ний өдөр

№ 10/26

Улаанбаатар хот

Охин компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.1, 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, “БиДиСЕК ҮЦК” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 3.19 дүгээр зүйл, 3.24 дүгээр зүйл, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 03-р сарын 11-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 100 хувийн хөрөнгө оруулалттай охин компани болох “Икс гурав зэт эй” ХХК-ийн нэрийг “Икс гурав зэт эй ББСБ” ХХК болгон өөрчилсүгэй.
2. “Икс гурав зэт эй ББСБ” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 10,000.00 (Арван мянга) төгрөг байсныг 5,000,000,000.00 (Таван тэрбум) төгрөг болгон нэмэгдүүлж, нэг бүр нь 100 (Нэг зуу) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий, нийт 50,000,000.00 (Тавин сая) ширхэг гаргасан энгийн хувьцаатай байхаар тогтоосугай.
3. “Икс гурав зэт эй ББСБ” ХХК-ийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг “зээлийн үйл ажиллагаа” болгон нэмсүгэй.
4. “Икс гурав зэт эй ББСБ” ХХК-ийн Хувь нийлүүлсэн хөрөнгийг энэхүү тогтоолын 2-т заасан хэмжээнд, Компанийн 2025 оны цэвэр ашгаас мөнгөн хөрөнгө хэлбэрээр оруулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Лхагвадорж)-д зөвшөөрсүгэй.
5. “Икс гурав зэт эй ББСБ” ХХК-ийн шинэчилсэн дүрмийг энэхүү тогтоолын нэгдүгээр Хавсралтаар баталсугай.
6. “Икс гурав зэт эй ББСБ” ХХК-ийн “Бизнес төлөвлөгөө”-г энэхүү тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:**



/Д.ДАЯНБИЛГҮҮН/